

2020 оны 12 сарын 1 өдөр
Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар

COVID-19 цар тахлын улмаас нутаг буцаж чадалгүй гацсан, японд амжиргаагаа залгуулах эх үүсвэргүйгээс, хөдөлмөр эрхлэх (цагийн ажил хийх) хүсэлтэй байгаа гадаадын иргэн танаа

COVID-19 цар тахлын улмаас нутаг буцаж чадалгүй гацсан, японд амжиргаагаа залгуулах эх үүсвэргүйгээс хэцүү нөхцөлд ороод байгаа гадаадын иргэнийг долоо хоногт 28 цагаас илүүгүй хугацаагаар хөдөлмөр эрхлэх (цагийн ажил хийх)-г зөвшөөрөхөөр боллоо.

Хөдөлмөр эрхлэх (цагийн ажил хийх) хүсэлтэй гадаадын иргэн дараах 2 шаардлагыг хангасан бол, орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын товчоонд хандаж, өөрийн оршин суух статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах өргөдлөө гаргана уу.

1 Оршин суух статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл ([дэлгэрэнгүйг эндээс авна уу](#))

2 Тавигдах шаардлага

- (1) Одоогийн оршин суух статусаар хөдөлмөр эрхлэх боломжгүй;
- (2) Нутаг буцаж чадалгүй гацсан;
- (3) Японд амьдардаг хамаатан садангүй эсвэл өөрийн харьяалагддаг байгууллагаас дэмжлэг авах боломжгүй гэх мэтчилэн нутаг буцах хүртэл амьжиргаагаа залгуулах эх үүсвэргүй;

3 Бүрдүүлэх баримт бичиг

- (1) [Оршин суух статусаас гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл](#)
- (2) Нутаг буцах боломжгүй үндэслэлтэй шалтгаан байгаа гэдгээ нотлох баримт (хэрэв та саяхан оршин суух статусаа өөрчлөх зөвшөөрөл хүссэн өргөдөл)

гаргасан бол дахин бүрдүүлж өгөх шаардлагагүй).

(3) Шалтгааныг тайлбарласан өргөдөл ([Эндээс](#) жишээ авна уу.)